



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/1406

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтууд, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алтаргана 2024" олон улсын XV их наадмын тэмцээн уралдааны сурталчилгааны самбарын эх бэлтгэл, хэвлэл, 90 секунд хугацаатай танилцуулга видео бэлтгэх ажлын гүйцэтгэгчээр "Аргун паблишинг" ХХК-тай 14,500,000 (арван дөрвөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. "Алтаргана 2024" наадмын сурталчилгааны самбарын эх бэлтгэл, хэвлэл, 90 секунд хугацаатай танилцуулга видео бэлтгэх бэлтгэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг "Аргун паблишинг" ХХК-ийн захирал (Д.Баярцэцэг)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн "Алтаргана 2024" арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010548